СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС

# СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

# 2021/05



УЛААНБААТАР ХОТ
2021 он

# АГУУЛГА


| | Хуудасны дугаар |
|---|---|
| НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ДҮҮРГЭЭР | 1 |
| ТӨСӨВ | 2 |
| ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ | 3 |
| АЖ ҮЙЛДВЭР | 11 |
| МАЛ АЖ АХУЙ | 12 |
| ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ | 14 |
| ЭРҮҮЛ МЭНД | 16 |
| ГЭМТ ХЭРЭГ | 18 |

Хүснэгт 2. Нийслэлийн эдийн засаг, нийгмийн үзүүлэлтүүд, дүүргээр

| Үзүүлэлт | Хэмжих Нэгж | 2020 I-V | | | | | 2021 I-V | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хотын дундаж | Хамгийн өндөр | | Хамгийн бага | | Хотын дундаж | Хамгийн өндөр | | Хамгийн бага | |
| **Хүн амын нягтрал** /нэг кв км-т ногдох хүн/ | Тоо | 315 | Баянгол | 7 699 | Налайх | 55 | 321 | Баянгол | 7 903 | Налайх | 57 |
| | | | Чингэлтэй | 1 704 | Багануур | 46 | | Чингэлтэй | 1 704 | Багануур | 48 |
| | | | Сүхбаатар | 702 | Багахангай | 30 | | Сүхбаатар | 697 | Багахангай | 32 |
| **Нялхсын нас баралт** /амьд төрсөн 1000 хүүхдэд/ | 0\00* | 11 | Сонгинохайрхан | 12 | Налайх | 8 | 10 | Налайх | 24 | Хан-Уул | 5 |
| | | | Чингэлтэй | 9 | Сүхбаатар | 4 | | Багануур | 12 | Баянзүрх | 5 |
| | | | Баянгол | 9 | Багахангай | - | | Сонгинохайрхан | 11 | Багахангай | - |
| 10 000 хүн тутмаас **халдварт өвчнөөр өвчлөгсөд** | 0\000 | 50 | Сонгинохайрхан | 46 | Сүхбаатар | 29 | 326 | Хан-Уул | 381 | Налайх | 251 |
| | | | Багануур | 46 | Хан-Уул | 26 | | Баянзүрх | 353 | Багануур | 75 |
| | | | Баянзүрх | 45 | Багахангай | 9 | | Баянгол | 333 | Багахангай | 46 |
| **Төсвийн орлого, зарлагын харьцаа** зарлага=100 | тоо | 71 | Сүхбаатар | 61 | Багануур | 10 | 98 | Чингэлтэй | 132 | Багануур | 14 |
| | | | Чингэлтэй | 59 | Налайх | 9 | | Хан-Уул | 69 | Налайх | 12 |
| | | | Хан-Уул | 41 | Багахангай | 8 | | Сүхбаатар | 67 | Багахангай | 10 |
| 16-аас дээш насны 10 000 хүнд ногдох **Гэмт хэрэг** | тоо | 81 | Сүхбаатар | 133 | Багахангай | 57 | 61 | Сүхбаатар | 86 | Налайх | 37 |
| | | | Баянгол | 96 | Налайх | 56 | | Хан-Уул | 67 | Багахангай | 37 |
| | | | Баянзүрх | 86 | Багануур | 39 | | Баянзүрх | 64 | Багануур | 29 |

Тайлбар: * промиль ** продицмил

## ДҮҮРГИЙН ТӨСӨВ

Дүүргийн төсвийн нийт орлого 2021 оны 5 сард 13.8 тэрбум төгрөг болж, төлөвлөснөөс 1.3(9.1%) тэрбум төгрөгөөр дутуу бүрджээ. Төсвийн нийт орлогын 8.5(88.8%) тэрбум төгрөгөөр татварын орлого, 0.36(100.9%) тэрбум төгрөгөөр татварын бус орлого, 4.8(94.1%) тэрбум төгрөгөөр тусламжийн орлого бүрджээ. 2021 оны 5 сард татварын нийт орлогын 1203.1(76.2%) сая төгрөгөөр орлогын албан татвар, 9.7(78.4%) сая төгрөгөөр өмчийн татвар, 972.6(56.1%) сая төгрөгөөр газрын төлбөр, 987.9(52.5%) сая төгрөгөөр бусад татвар хураамжаас тус тус бүрдүүлсэн байна.

Хүснэгт 2. Дүүргийн төсвийн нийт орлого, сая төгрөгөөр

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь |
|---|---|---|---|
| НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 15 217 | 13 833.3 | 90.9 |
| А. Урсгал орлого | 10 046.3 | 8 967.3 | 89.3 |
| 1. Татварын орлого | 9 680.2 | 8 597.8 | 88.8 |
| 1. Орлогын албан татвар | 6 049.4 | 6 626.6 | 109.5 |
| 1.1. Хувь хүний орлогын албан татвар | 1 578.7 | 1 203.2 | 76.2 |
| 1.2. Хувь хүнээс суутгасан орлогын албан татвар | 1 080.5 | 795.4 | 73.6 |
| 1.3. Иргэний хадгаламжийн хүүгийн орлого | 3 095.6 | 3 472.5 | 112.2 |
| 1.4. Хөрөнгө борлуулсны орлогын албан татвар | 294.7 | 1 155.6 | 392.2 |
| 2. Өмчийн татвар | 12.4 | 9.7 | 78.5 |
| 2.1Бууны албан татвар | 12.4 | 9.7 | 78.5 |
| 3. Газрын төлбөр | 1 731 | 972.6 | 56.2 |
| 3.1Газрын 40 хувь | 1 731 | 972.6 | 56.2 |
| 4. Дотоодын бараа үйлчилгээний татвар | 7.6 | 0.9 | 12.7 |
| 4.1.Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр | 7.6 | 0.9 | 12.7 |
| 5.Бусад татвар | 1 879.8 | 987.9 | 52.6 |
| 5.1. Улсын тэмдэгтийн хураамж | 420.4 | 369.6 | 87.9 |
| 5.2. Ус, рашаан ашигласны төлбөр | 1.04 | 2.8 | 264.6 |
| 5.3. Хог хаягдлын хураамж | 1 458.4 | 615.6 | 42.2 |
| 2.Татварын бус орлого | 366.2 | 369.5 | 100.9 |
| 2.1.Хүү,торгуулийн орлого | 217.4 | 272.3 | 125.3 |
| 2.2.Төсөвт газрын өөрийн орлого | 44.2 | 26.7 | 60.4 |
| 2.3.бусад нэр заагдаагүй орлого | 104.6 | 70.4 | 67.3 |
| 3.Тусламжийн орлого | 5 170.7 | 4 865.9 | 94.1 |
| 1. Нийслэлийн төсвөөс авсан санхүүгийн дэмжлэг | 4 500 | 4 500 | 100 |
| 2. Орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг | 670.7 | 365.9 | 54.6 |

Тайлант хугацааны орлогын албан татвар төлөвлөснөөс 577.3(9.5%) сая төгрөгөөр өссөн байна. Өмчийн татвар төлөвлөснөөс 2.7(21.5%) сая төгрөгөөр, Газрын төлбөр 758.4(43.8%) сая төгрөгөөр, Дотоодын бараа үйлчилгээний татвар 6.6(87.3%) сая төгрөгөөр, бусад татвар 891.8(47.4%) сая төгрөгөөр тус тус тасарсан байна. Иргэний хадгаламжийн хүүгийн орлого 376.9(12.2%) сая төгрөгөөр, хөрөнгө борлуулсны орлогын албан татвар 860.9(292.2%) сая төгрөгөөр тус тус өссөн бол хувь хүнээс суутгасан орлогын албан татвар 285.1(26.4%) сая төгрөгөөр, хувь хүний орлогын албан татвар 375.5(23.8%) сая төгрөгөөр буурчээ.

## ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

2021 оны 5-р сарын 28-ний байдлаар, Өрхийн хэрэглээний үнийн ажиглалтаар Хангай захад 1 шуудай хар модны дундаж үнэ 3500 төгрөг байгаа нь өмнөх сарын мөн үетэй харьцуулахад ижил ханштай байна.

Зураг 1. Шатахууны үнэ, 5-р сард, төгрөгөөр :




Дүүргийн нутаг дэвсгэрт байрладаг ШТС-уудад 5-р сард АИ-92 шатахуун дунджаар 1450 төгрөг, АИ-95 шатахуун 2100 төгрөг, дизель түлш 2290 төгрөг байна.

2021 оны 5-р сард дүүргийн хүнсний зах, дэлгүүрт жижиглэн худалдаалж буй махны дундаж үнийг өмнөх сартай харьцуулахад 1 кг үхрийн ястай мах 13564 (2259), төгрөгөөр өссөн ба үхрийн цул мах 14998 (89) төгрөгөөр , буурсан байна.Үүнээс 1кг адууны мах 13500 төгрөг, мөн 1кг ямааны ястай мах 8832 төгрөг байгаа нь өмнөх сарын үнэтэй харьцуулахад ижил ханштай байна. Харин 1 кг хонины ястай мах 10274 төгрөг байгаа нь өмнөх сартай харьцуулж үзэхэд (43) төгрөгөөр буурсан байна.

Өнгөрсөн оны 5-р сард 1 кг хонины ястай мах 9688 төгрөг, үхрийн 1 кг ястай мах 10473 төгрөг байсан байна. Өнгөрсөн оны мөн үеэс хонины ястай махны үнэ 586 төгрөгөөр өссөн бол үхрийн ястай мах 3091 төгрөгөөр тус тус өссөн байна.

Зураг 2. Хонины ястай махны дундаж үнэ, төгрөгөөр, 5 сарын байдлаар:



Зураг 3. Үхрийн ястай махны дундаж үнэ, төгрөгөөр, 5 сарын байдлаар




Зураг 4. Ямааны ястай махны дундаж үнэ, төгрөгөөр, 5 сарын байдлаар




Зураг 5. Адууны ястай махны дундаж үнэ, төгрөгөөр, 5 сарын байдлаар:




Тайлант оны 5-р сард дүүргийн нутаг дэвсгэр дээрх хүнсний дэлгүүр, зах, худалдааны төвүүдэд жижиглэнгээр худалдаалж буй монгол төмс 1 кг нь дунджаар 910 төгрөг байгаа нь өмнөх сараас 17 төгрөгөөр, монгол байцай 1 кг дунджаар 2660 төгрөг байгаа нь өмнөх сараас 225 төгрөгөөр тус тус буурсан байна.Харин монгол лууван 1 кг нь дунджаар 1653 байгаа нь өмнөх сараас 241 төгрөгөөр өсөж, хятад сонгино 1 кг нь дунджаар 2295 төгрөг байгаа нь өмнөх сараас 270 төгрөгөөр тус тус буурсан ханштай байна.

Зураг 6. Хүнсний ногооны дундаж үнэ, төгрөгөөр, 5 сарын байдлаар:




Дүүргийн хүнсний зах, дэлгүүрт худалдаалагдаж буй Алтан тарианы савласан дээд гурилын дундаж үнэ 1 кг нь 1595 төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1420(175) төгрөгөөр буурсан, 1-р гурил 1кг нь дунджаар 1440 төгрөг байгаа нь 1138(302) төгрөгөөр тус тус буурсан ханштай байна.

Зураг 7. Алтан тарианы савласан дээд гурилын дундаж үнэ, **төгрөгөөр,** 5 сарын байдлаар:




2021 оны 4 дүгээр сард үнийн ажиглалт хийхээр хэрэглээний сагсанд сонгогдсон 344 нэрийн бараа, үйлчилгээний 15.4 хувийнх нь үнэ өсөж, 1.7 хувийнх нь үнэ буурч, 82.9 хувийн бараа үйлчилгээний үнэ өмнөх сартай харьцуулахад тогтвортой байв.

Хүснэгт 4. Хүнсний барааны дундаж үнийн зэрэгцүүлэлт, 2017-2021 оны 5-р сараар

| | | | хэмжих нэгж | 2017.V | 2018.V | 2019.V | 2020.V | 2021.V | 2021/2020 | 2021/2019 | 2021/2018 | 2021/2017 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | "Алтан тариа" савласан гурил | дээдийн дээд | кг | 1616 | 1645 | 1900 | 1900 | 2172 | 114.3 | 114.3 | 132.0 | 134.4 |
| | | дээд | кг | 1294 | 1372 | 1420 | 1420 | 1595 | 112.3 | 112.3 | 116.3 | 123.3 |
| | | 1-р зэрэг | кг | 1063 | 1075 | 1128 | 1138 | 1440 | 126.5 | 127.7 | 134.0 | 135.5 |
| | | 2-р зэрэг | кг | 843 | 854 | 878 | 893 | 988 | 110.6 | 112.5 | 115.7 | 117.2 |
| 4 | Сүү | Сүү ХК 1л | литр | 2369 | 2658 | 2696 | 2756 | 2847 | 103.3 | 105.6 | 107.1 | 120.2 |
| | | Сүү ХК 0.5л | литр | 1013 | 1102 | 1130 | 1214 | 1313 | 108.2 | 116.2 | 119.1 | 129.6 |
| | | Задгай | литр | 1450 | 1750 | 1633 | 1933 | 1720 | 89.0 | 105.3 | 98.3 | 118.6 |
| 5 | Тараг, Цөцгийтэй | | литр | 2236 | 2568 | 2552 | 2630 | 2722 | 103.5 | 106.7 | 106.0 | 121.7 |
| 6 | Талх | Атар | ширхэг | 1139 | 1165 | 1310 | 1336 | 1224 | 91.6 | 93.4 | 105.1 | 107.5 |
| | | Зууван чех | ширхэг | 1243 | 1392 | 1416 | 1602 | 1741 | 108.7 | 123.0 | 125.1 | 140.1 |
| | | Хар талх | 300 гр | 902 | 924 | 998 | 1120 | 1302 | 116.3 | 130.5 | 140.9 | 144.3 |
| 7 | Будаа | цагаан | кг | 3193 | 3330 | 3780 | 4050 | 4050 | 100.0 | 107.1 | 121.6 | 126.8 |
| | | шар | кг | 1853 | 1720 | 1800 | 2250 | 1673 | 74.4 | 92.9 | 97.3 | 90.3 |
| 8 | Цөцгийн тос, "Сүү" ХК | | 250 гр | 3238 | 3238 | 3943 | 4000 | 4493 | 112.3 | 113.9 | 138.7 | 138.8 |
| 9 | Ургамлын тос, "Янта" | | 1 литр | 3476 | 3685 | 3878 | 3898 | 4169 | 107.0 | 107.5 | 113.1 | 119.9 |
| 10 | Ногоон цай, Гүрж | | 90 гр | 1533 | 1573 | 1568 | 1568 | 1558 | 99.4 | 99.4 | 99.0 | 101.6 |
| 11 | Элсэн чихэр | | кг | 3454 | 3517 | 3535 | 3535 | 2916 | 82.5 | 82.5 | 82.9 | 84.4 |
| 12 | Хонины мах | ястай | кг | 6108 | 6266 | 8583 | 9688 | 10274 | 106.0 | 119.7 | 164.0 | 168.2 |
| 13 | Үхрийн мах | ястай | кг | 7068 | 8353 | 10250 | 10473 | 13564 | 129.5 | 132.3 | 162.4 | 191.9 |
| | | цул | кг | 8138 | 9550 | 12833 | 12833 | 14998 | 116.9 | 116.9 | 157.0 | 184.3 |
| 14 | Адууны мах, ястай | | кг | 6050 | 6500 | 8500 | 10000 | 13500 | 135.0 | 158.8 | 207.7 | 223.1 |
| 15 | Ямааны мах, ястай | | кг | 5550 | 4417 | 8200 | 8500 | 8832 | 103.9 | 107.7 | 200.0 | 159.1 |
| 16 | Төмс, монгол | | кг | 714 | 1492 | 1030 | 888 | 910 | 102.5 | 88.3 | 61.0 | 127.5 |
| 17 | Лууван, монгол | | кг | 1232 | 2425 | 1423 | 1633 | 1653 | 101.2 | 116.2 | 68.2 | 134.2 |
| 18 | Байцаа, монгол | | кг | 1784 | 1954 | 1798 | 1888 | 2660 | 140.9 | 147.9 | 136.1 | 149.1 |
| 19 | Хүрэн манжин, монгол | | кг | 1758 | 4176 | 1438 | 1890 | 2122 | 112.3 | 147.6 | 50.8 | 120.7 |
| 20 | Сонгино, хятад | | кг | 1306 | 1238 | 1204 | 1580 | 2295 | 145.3 | 190.6 | 185.4 | 175.7 |
| 21 | Алим, фужи | | кг | 4856 | 4807 | 4786 | 5546 | 6193 | 111.7 | 129.4 | 128.8 | 127.5 |
| 22 | Өндөг, Дотоод | | ширхэг | 351 | 360 | 364 | 366 | 457 | 124.9 | 125.5 | 126.9 | 130.2 |

Хүснэгт 3. Хүнсний барааны дундаж үнийн зэрэгцүүлэлт, 2020 оны IV-XII сар, 2021 оны I-V сар:

| | | хэмжих нэгж | 2020.04.28 | 2020.05.28 | 2020.06.28 | 2020.07.28 | 2020.08.28 | 2020.09.28 | 2020.10.28 | 2020.11.28 | 2020.12.28 | 2021.01.28 | 2021.02.28 | 2021.03.28 | 2021.04.28 | 2021.05.28 | 19.IX.28 19.X.28 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| "Алтан тариа" савласан гурил | дээдийн дээд | кг | 1900 | 1900 | 1900 | 1900 | 1900 | 2245 | 2250 | 2250 | 2250 | 2250 | 2252 | 2252 | 2221 | 2172 | -2.2 |
| | дээд | кг | 1420 | 1420 | 1420 | 1420 | 1420 | 1570 | 1582 | 1574 | 1574 | 1610 | 1610 | 1610 | 1593 | 1595 | 0.1 |
| | 1-р зэрэг | кг | 1138 | 1138 | 1138 | 1138 | 1138 | 1302 | 1310 | 1312 | 1312 | 1326 | 1347 | 1326 | 1409 | 1440 | 2.2 |
| | 2-р зэрэг | кг | 893 | 893 | 895 | 895 | 895 | 986 | 987 | 987 | 987 | 1000 | 1035 | 980 | 980 | 988 | 0.8 |
| Сүү | Сүү ХК 1л | литр | 2576 | 2576 | 2576 | 2576 | 2756 | 2830 | 2852 | 2852 | 2852 | 2860 | 2862 | 2878 | 2864 | 2847 | -0.6 |
| | Сүү ХК 0.5л | литр | 1192 | 1214 | 1214 | 1214 | 1214 | 1276 | 1322 | 1322 | 1322 | 1334 | 1308 | 1293 | 1332 | 1313 | -1.4 |
| | Задгай | литр | 1933 | 1933 | 1467 | 1467 | 1433 | 1550 | 1548 | 1548 | 1548 | 1548 | 1430 | 1328 | 1766 | 1720 | -2.6 |
| Тараг, Цөцгийтэй | | литр | 2630 | 2630 | 2630 | 2630 | 2630 | 2696 | 2702 | 2702 | 2702 | 2702 | 2812 | 2836 | 2835 | 2722 | -4.0 |
| Талх | Атар | ширхэг | 1336 | 1336 | 1336 | 1336 | 1336 | 1306 | 1292 | 1292 | 1292 | 1245 | 1250 | 1250 | 1216 | 1224 | 0.7 |
| | Зуухан чех | ширхэг | 1600 | 1602 | 1602 | 1602 | 1602 | 1622 | 1643 | 1643 | 1643 | 1712 | 1743 | 1721 | 1732 | 1741 | 0.5 |
| | Хар талх | 300 гр | 1120 | 1120 | 1120 | 1120 | 1120 | 1214 | 1248 | 1248 | 1248 | 1352 | 1307 | 1307 | 1244 | 1302 | 4.7 |
| Будаа | цагаан заантай | кг | 4050 | 4050 | 4050 | 4050 | 4050 | 4025 | 4025 | 4025 | 4025 | 4000 | 4033 | 4050 | 4050 | 4050 | 0.0 |
| | шар | кг | 1925 | 2250 | 2250 | 2250 | 2250 | 2350 | 2345 | 2345 | 2345 | 2345 | 2345 | 2345 | 1755 | 1673 | -4.7 |
| Цөцгийн тос, "Сүү" ХК | | 200 гр | 3943 | 4000 | 4000 | 3827 | 3827 | 4107 | 4097 | 4097 | 4097 | 4097 | 4097 | 4097 | 4493 | 4493 | 0.0 |
| Ургамлын тос, "Янта" | | 1 литр | 3898 | 3898 | 3938 | 3958 | 3958 | 3868 | 3857 | 3857 | 3857 | 4618 | 4409 | 4515 | 4701 | 4169 | -11.3 |
| Ногоон цай, Гүрж | | 90 гр | 1568 | 1568 | 1568 | 1568 | 1568 | 1576 | 1604 | 1604 | 1604 | 1784 | 1775 | 1555 | 1572 | 1558 | -0.9 |
| Элсэн чихэр /заантай/ | | кг | 3570 | 3570 | 3570 | 3570 | 3535 | 3345 | 3337 | 3337 | 3337 | 3177 | 3275 | 3275 | 2880 | 2916 | 1.3 |
| Хонины мах | ястай | кг | 8850 | 9688 | 9600 | 9100 | 8733 | 7617 | 7601 | 7676 | 7807 | 8175 | 8989 | 10748 | 10317 | 10274 | -0.4 |
| Үхрийн мах | ястай | кг | 10173 | 10473 | 10473 | 10233 | 10367 | 9567 | 9412 | 9554 | 9587 | 11263 | 11431 | 12315 | 11305 | 13564 | 20.0 |
| | цул | кг | 12333 | 12833 | 12833 | 12833 | 11100 | 10733 | 10662 | 11720 | 11767 | 12698 | 12792 | 12619 | 15087 | 14998 | -0.6 |
| Адууны мах, ястай | | кг | 9800 | 10000 | 10000 | 9000 | 9000 | 9000 | 9000 | 7937 | 7937 | 7937 | 8746 | 8746 | 13500 | 13500 | 0.0 |
| Ямааны мах, ястай | | кг | 8500 | 8500 | 8500 | 8000 | 8000 | 8000 | 8000 | 8000 | 8000 | 8500 | 8500 | 8500 | 8832 | 8832 | 0.0 |
| Төмс, монгол | | кг | 998 | 888 | 1738 | 1818 | 818 | 706 | 657 | 714 | 894 | 815 | 769 | 749 | 927 | 910 | -1.8 |
| Лууван, монгол | | кг | 1663 | 1633 | 1800 | 1738 | 1498 | 1135 | 1064 | 1082 | 1330 | 1202 | 1265 | 1152 | 1412 | 1653 | 17.1 |
| Байцаа, монгол | | кг | 1990 | 1888 | 2500 | 1998 | 1758 | 1208 | 1093 | 1168 | 1283 | 1345 | 1595 | 1543 | 2435 | 2660 | 9.2 |
| Хүрэн манжин, монгол | | кг | 1968 | 1890 | 2498 | 2398 | 1998 | 1495 | 1441 | 1818 | 1818 | 1743 | 1767 | 1566 | 2383 | 2122 | -11.0 |
| Сонгино, хятад | | кг | 1550 | 1580 | 1500 | 1480 | 1440 | 1726 | 1713 | 1792 | 1746 | 1784 | 2031 | 1910 | 2565 | 2295 | -10.5 |
| Алим, фужи | | кг | 5546 | 5546 | 5546 | 5278 | 5158 | 5206 | 5088 | 5088 | 5088 | 5574 | 5751 | 5770 | 6469 | 6193 | -4.3 |
| Өндөг, ОХУ | | ширхэг | 366 | 366 | 366 | 362 | 362 | 366 | 363 | 371 | 371 | 377 | 478 | 437 | 425 | 457 | 7.5 |

## АЖ ҮЙЛДВЭР

Дүүргийн аж үйлдвэрийн газрууд 2021 оны эхний 5-р сард 277.9 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 308.3 тэрбум төгрөгийн борлуулалт хийжээ. Дүүргийн аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн 233.1(83.8%) тэрбум төгрөгийг хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, 44.8(16.2%) тэрбум төгрөгийг хүнсний бус бүтээгдэхүүний үйлдвэрлэл эзэлж байна. Нийт хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 41.7(17.8%) тэрбум төгрөгийг мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэл, 82.0(35.1%) тэрбум төгрөгийг сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, 54.7(23.4%) тэрбум төгрөгийг үр тарианы гурил, малын тэжээлийн үйлдвэрлэл, 16.8(7.2%) тэрбум төгрөгийг ундаа үйлдвэрлэл, 37.7(16.1%) тэрбум төгрөгийг хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл эзэлж байна.

Хүснэгт 5. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалт, эдийн засгийн ангиллаар, сая төгрөгөөр

| Салбар | Үйлдвэрлэл | Борлуулалт |
|---|---|---|
| **Бүгд** | **277933.4** | **308313.2** |
| ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮН, УНДАА ҮЙЛДВЭРЛЭЛ | 233180.1 | 259640.9 |
| Мах, загас, жимс, ногоо, өөх, тос боловсруулалт | 41810.2 | 46661.9 |
| Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл | 82019.7 | 85832.2 |
| Үр тарианы гурил, цардуул, малын тэжээл | 54736.6 | 56193.9 |
| Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл | 37758.4 | 38459.2 |
| Архи ус ундаа үйлдвэрлэл | 16855.0 | 32493.6 |
| ХҮНСНИЙ БУС БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ | 44753.3 | 48672.3 |
| Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл | 8162.2 | 8162.2 |
| Машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл | 679.5 | 840.1 |
| Бусад үйлдвэрлэл | 35911.6 | 39670.0 |

Оны эхний 5 сард нийт үйлдвэрлэсэн хүнсний бус бүтээгдэхүүний 8.1(18.1%) тэрбум төгрөгийг химийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, 0.67(1.4%) тэрбум төгрөгийг машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэлийн үйлдвэрлэл, 35.9(80.3%) тэрбум төгрөгийн бусад хүнсний бус бүтээгдэхүүний үйлдвэрлэл эзэлж байна.

Дүүргийн аж үйлдвэрийн газруудын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн өнгөрсөн оны мөн үеэс 28.1(9.1%) тэрбум төгрөгөөр буурч, борлуулалт өнгөрсөн оны мөн үеэс 4.5(1.4%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Тайлант оны эхний 5 сард үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалтын 259.6(84.2%) тэрбум төгрөгийг хүнсний бүтээгдэхүүний борлуулалт, 48.6(15.7%) тэрбум төгрөгийг хүнсний бус бүтээгдэхүүний борлуулалт тус тус эзэлж байна.

Зураг 7. Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалт, тэрбум төгрөгөөр




Тайлант хугацаанд нийт хүнсний бүтээгдэхүүний борлуулалтын 11.5(19.3%) тэрбум төгрөгийг мах, махан бүтээгдэхүүний борлуулалт, 20.9(35.1%) тэрбум төгрөгийг сүү, сүүн

бүтээгдэхүүний борлуулалт, 11.1(18.6%) тэрбум төгрөгийг үр тарианы гурил, малын тэжээлийн борлуулалт, 6.0(10.0%) тэрбум төгрөгийг ундааны борлуулалт, 9.9(16.6%) тэрбум төгрөгийг хүнсний бусад бүтээгдэхүүний борлуулалт эзэлж байна. Хүнсний бус бүтээгдэхүүний нийт борлуулалтын 1.8(13.8%) тэрбум төгрөгийг химийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, 0.24(1.8%) тэрбум төгрөгийг машин тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэлийн үйлдвэрлэл, 10.9(83.8%) тэрбум төгрөгийн бусад хүнсний бус бүтээгдэхүүний борлуулалт эзэлж байна.

Хүснэгт 6. Хүнсний гол нэр төрлийн зарим бүтээгдэхүүний үйлдвэрлэлт

| Бүтээгдэхүүний нэр төрөл | Хэмжих нэгж | Биет хэмжээ | | Үнийн дүнгээр (сая.төг) | |
|---|---|---|---|---|---|
| | | 1-12 сар | 5 сар | 1-12 сар | 5 сар |
| Үхрийн мах | тн | 56.8 | 7.2 | 510.6 | 80.5 |
| Гахайн мах | тн | 258.1 | 63.8 | 2440.1 | 665.9 |
| Хонины мах | тн | 255.7 | 8.8 | 1789.2 | 75.1 |
| Ямааны мах | тн | 652.1 | 111 | 5085.2 | 886.5 |
| Адууны мах | тн | 1525 | 425 | 8274.9 | 2309.6 |
| Хиамны зүйл | тн | 1320.3 | 314.7 | 20052.1 | 4823.5 |
| Боловсруулсан шингэн сүү | мян.л | 10825.7 | 2438.1 | 27945.7 | 6279.6 |
| Тараг | мян.л | 4612.2 | 1095.2 | 12920.1 | 3137.6 |
| Аарцны ундаа | мян.л | 1708.6 | 334.8 | 3745.4 | 581.6 |
| Цөцгийн тос | тн | 22.1 | 0.5 | 441.4 | 12.4 |
| Аарц | тн | 163.8 | 37.9 | 3182.2 | 804.0 |
| Гурил Дээд | тн | 14540.8 | 3286.8 | 17548.0 | 4050.1 |
| Гурил I зэрэг | тн | 23466.5 | 5339.3 | 22639.8 | 5072.1 |
| Гурил II зэрэг | тн | 3300.4 | 982.3 | 2363.0 | 695.1 |
| Нарийн боов | тн | 2311.8 | 544.1 | 11330.9 | 2592.9 |
| Талх | тн | 6605.5 | 1570.5 | 18407.9 | 4519.6 |
| Гоймон | тн | 838.0 | 215.4 | 1761.5 | 473.3 |
| Спирт | мян.л | 451 | 132 | 2762.2 | 808.4 |
| Архи | мян.л | 1064.9 | 208.8 | 9830.1 | 1942.6 |
| Амны хаалт (маск) | мян.ш | | | | |
| Нүүрсэн шахмал түлш | Тн | 56564.7 | 3359.2 | 8484.7 | 503.8 |
| Тарилгын эм | мян.ампул | 242.3 | 18.7 | 264.4 | 33.0 |
| Шахмал эм | мян.боодол | 6591.2 | 1823.9 | 4584.3 | 1202.1 |
| Шингэн эм | тн | 15.4 | 4.1 | 520.8 | 128.0 |
| Эмчилгээ, урьдчилан сэргийлэх зориулалттай бусад төрлийн эм, ариутгалын бэлдмэл | мян.л | 125500.2 | 37059.1 | 2824.1 | 799.0 |

Сонгинохайрхан дүүргийн махны үйлдвэрүүд оны эхний 5 сард 56.8 тонн үхрийн мах, 255.7 тонн хонины мах, 652.1 тонн ямааны мах, 1525 тонн адууны мах боловсруулсан бол 5 дугаар сард 7.2 тонн үхрийн мах, 8.8 тонн хонины мах, 111 тонн ямааны мах, 425 тонн адууны мах үйлдвэрлэсэн байна. Сүүний үйлдвэрүүд 5-р сард 2438.1 мянган литр шингэн сүү, 1095.2 мянган литр тараг, 334.8 мянган литр аарцны ундаа үйлдвэрлэсэн байна. Гурилын үйлдвэрүүд оны эхний 5 сард нэгдүгээр зэргийн гурил 23466.5 тонныг үйлдвэрлэсэн байна. Дүүргийн хүнсний үйлдвэрүүд 5 сард 1570.5 тонн талх, 544.1 тонн нарийн боов, 215.4 тонн гоймон үйлдвэрлэжээ.

Эм, эмнэлгийн бүтээгдэхүүний үйлдвэрүүд 18.7 мянган ширхэг тарилгын эм, 4.1 тонн шингэн эм, 37059.1 мянган литр эмнэлгийн ариутгалын бэлдмэл үйлдвэрлэсэн байна.

# ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ

2021 оны 5-р сарын байдлаар бүртгэлтэй ажил хайгч иргэдийн тоо 306 байгаагаас 149(48.6%) нь эмэгтэйчүүд байна. Бүртгэлтэй ажил хайгч иргэдийн 5(1.6%) нь магистр, доктор, 90(29.4%) нь дипломын болон бакалаврын дээд, 15(4.9%) нь тусгай мэргэжлийн дунд, 7(2.2%) нь техникийн болон мэргэжлийн, 115(37.5%) нь бүрэн дунд, 5(1.6%) нь суурь, 3(0.9%) нь бага түвшиний боловсролтой, 2(0.6%) нь боловсролгүй, 2(0.6%) нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна.

Хүснэгт 15. Бүртгэлтэй ажил хайгч иргэдийн тоо, боловсролын түвшин, насны бүлгээр

<table>
<tr><td rowspan="2">Ажил хайгч иргэн /сарын эцэст/</td><td colspan="9">Боловсролын түвшин</td></tr>
<tr><td>Боловсролгүй</td><td>Бага</td><td>Суурь</td><td>Бүрэн дунд</td><td>Техникийн болон мэргэжлийн</td><td>Тусгай мэргэжлийн дунд</td><td colspan="2">Дипломын болон бакалаврын дээд</td><td>Магистр, доктор</td></tr>
<tr><td rowspan="4">242</td><td>2</td><td>3</td><td>5</td><td>115</td><td>7</td><td>15</td><td colspan="2">90</td><td>5</td></tr>
<tr><td rowspan="2">Хөгжлийн бэрхшээлтэй иргэд</td><td colspan="8">Насны бүлэг</td></tr>
<tr><td>15-24</td><td>25-34</td><td>35-44</td><td>45-54</td><td colspan="2">55-59</td><td colspan="2">60+</td></tr>
<tr><td>2</td><td>22</td><td>96</td><td>76</td><td>31</td><td colspan="2">16</td><td colspan="2">1</td></tr>
</table>

Бүртгэлтэй ажил хайгч иргэдийн 22(7.1%) нь 15-24 насны, 96(31.3%) нь 25-34 насны, 76(24.8%) нь 35-44 насны, 31(10.1%) нь 45-54 насны, 16(5.2%) нь 55-59 насны, 1(0.3%) нь 60, түүнээс дээш насны иргэд байна. Бүртгэлтэй ажил хайгч иргэдээс 9 хүн ажилд зуучлагдан орсноос 1(11.1%) нь 15-24 насныхан, 3(33.3%) нь 25-34 насныхан, 3(33.3%) нь 35-44 насныхан, 1(11.1%) нь 45-54 насныхан, 1(11.1%) нь 55-59 насны иргэд байна. Ажил хайгч иргэдийн 12(3.9%) нь шилжин суурьшсан, 18(5.8%) нь сургууль төгсөөд ажилгүй байгаа шалтгаанаар ажил хайж байгаа иргэд байна.

Зураг 13. Ажилд зуучлагдан орсон иргэдийн тоо насны бүлгээр, хүйсээр



Зураг 14. Ажилд зуучлагдан орсон иргэд, боловсролын түвшингээр, хувиар




Ажилд зуучлагдан орсон иргэдийн 2(22.2%) нь дипломын болон бакалаврын дээд боловсролтой, 1(11.1%) нь тусгай мэргэжлийн дунд боловсролтой, 2(22.2%) нь техникийн болон мэргэжлийн, 4(44.4%) нь бүрэн дунд боловсролтой иргэд байна.

Хүснэгт 16. Ажил хайгч иргэдийн тоо, 5-р сард

| Үзүүлэлтүүд | | Бүгд |
|---|---|---|
| **Ажил хайгч иргэн /сарын эхэнд/** | | **306** |
| Эмэгтэй | | 149 |
| Тайлант хугацаанд нэмэгдсэн иргэн | | 62 |
| Эмэгтэй | | 31 |
| Ажил хайж байгаа /шалтгаанаар/ | Шилжин суурьшсан | 12 |
| | Сургууль төгсөөд ажилгүй байгаа | 18 |
| | Сургуулиа орхисон /гарсан, чөлөө авсан/ | 1 |
| | Цэргээс халагдаад ажилгүй байгаа | 1 |
| | Гадаадаас эргэж ирсэн | 0 |
| | Хөдөлмөрийн насанд хүрч асрамжийн газраас гарсан | 0 |
| Ажлаас чөлөөлөгдсөн / халагдсан/ | Мэргэжлийн ур чадварын хувьд тэнцэхгүй болсон | 4 |
| | Эрүүл мэндийн хувьд тэнцэхгүй болсон | 0 |
| | Тэтгэвэрт гарсан | 0 |
| | Хөдөлмөрийн сахилгын зөрчил гаргасан | 1 |
| | Орон тооны цомхотголд орсон | 5 |
| | Байгууллага татан буугдсан | 5 |
| | Бусад | 15 |
| Тайлант хугацаанд хасагдсан иргэн | | 126 |
| Ажилд зуучлагдан орсон иргэн | | 9 |
| **Ажил хайгч иргэн /сарын эцэст/** | | **242** |
| Эмэгтэй | | 117 |

Тайлант хугацаанд 126 иргэн бүртгэлээс хасагдаж, 62 иргэн бүртгэлд шинээр нэмэгдсэн байна. Шинээр бүртгүүлсэн иргэдийн 30(48.3%) нь ажлаас чөлөөлөгдсөн шалтгаанаар бүртгүүлсэн байна. Нийт ажлаас чөлөөлөгдсөн иргэдийн 4(6.4%) нь мэргэжлийн ур чадвар тэнцэхгүй болсноос, 5(8.0%) нь байгууллага татан буугдсанаас, 5(8.0%) нь орон тооны цомхотголд орсноос, 1(1.6%) хөдөлмөрийн сахилга зөрчсөн, 15(24.1%) нь бусад шалтгаанаар ажилгүй болсон байна.

## ЭРҮҮЛ МЭНД

2021 оны эхний 05 сард 2893 эхээс 2863 хүүхэд мэндэлсэн байна. Өнгөрсөн оны мөн үед 2932 эхээс 2958 хүүхэд мэндэлж байжээ. Тайлант хугацаанд 0-1 насны хүүхдийн эндэгдэл 33 гарсан нь өмнөх оны мөн үеэс 3(8.3%)-аар буурсан, 1-5 насны хүүхдийн эндэгдэл 3 гарсан байгаа нь өмнөх оны мөн үеэс 3 (50%)-аар буурсан байна. Харин тайлант хугацаанд эхийн эндэгдэл 0 гарсан байна. Тайлант оны 5 сард 0-1 настай хүүхдийн эндэгдэл 1000 амьд төрөлтөнд 11.4 промилл ногдож байгаа нь өнгөрсөн оноос 0.8 промиллоор буурсан байна.

Хүснэгт 8. Төрөлт, нас баралт

| Үзүүлэлтүүд | 2020.05 | | 2021.05 | |
|---|---|---|---|---|
| | Бодит тоо | 1000 хүн амд | Бодит тоо | 1000 хүн амд |
| Төрсөн эх | 2932 | | 2863 | |
| Амьд төрсөн нярай | 2958 | | 2893 | |
| Нийт нас баралт | 663 | | 630 | |
| 0-1 насны хүүхдийн эндэгдэл | 36 | 12.2 | 33 | 11.4 |
| 1-5 насны хүүхдийн эндэгдэл | 6 | 2.0 | 3 | 1.0 |
| Эхийн эндэгдэл | 2 | 67.6 | 0 | 0 |

Тайлант хугацаанд халдварт өвчнөөр өвчилсөн 8392 хүн бүртгэгдсэн нь өмнөх оноос 6342 (309.3%) тохиолдлоор өссөн бөгөөд 10000 хүнд ногдох халдварт өвчин 257.7 промилл байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 194 (304.5%) промиллоор өссөн байна. Халдварт өвчний гаралтыг өмнөх оны мөн үетэй харьцуулбал цусан суулга 0 тохиолдол, улаан эсэргэнэ 0 тохиолдол, гепатит 3 тохиолдол, салхинцэцэг 1 тохиолдол, сальмонеллёз 0 тохиолдол, ёлом 0 тохиолдол, ГХА өвчин 0 тохиолдол, хоолны хордлого 0 тохиолдол, Эритема B08.3 0 тохиолдол, Төрөлхийн тэмбүү 0, тус тус илэрсэн байна. Тэмбүү 234 (63.0%), Шинээр илэрсэн сүрьеэ өвчин 118(47.5%), Трихомониаз 82(65.6%), Заг хүйтэн 234(78.2%) тохиолдлоор тус тус буурсан байна. Харин Ковид-19 халдвар 8002 тохиолдлоор ихэссэн байна.

Хүснэгт 9. Халдварт өвчний гаралт, төрлөөр

| Үзүүлэлтүүд | 2020.05 | | 2021.05 | | УБ хот | |
|---|---|---|---|---|---|---|
| | Бодит тоо | 10000 хүн амд | Бодит тоо | 10000 хүн амд | Бодит тоо | 10000 хүн амд |
| Бүгд халдварт өвчин | 2050 | 63.7 | 8392 | 257.7 | 46408 | 318.5 |
| Үүнээс цочмог халдварт өвчин | 438 | 13.6 | 8017 | 246.2 | 44107 | 302.7 |
| Цусан суулга | 164 | 5.1 | 0 | 0 | 8 | 0.1 |
| Улаан эсэргэнэ | 19 | 0.6 | 0 | 0 | 1 | 0 |
| Менингит | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Гепатит | 21 | 0.7 | 3 | 0.1 | 24 | 0.2 |
| Салхинцэцэг | 167 | 5.2 | 1 | 0 | 13 | 0.1 |
| Гахайн хавдар | 7 | 0.2 | 0 | 0 | 0 | 0 |
| Сальмонеллёз | 25 | 0.8 | 0 | 0 | 0 | 0 |
| Ёлом | 7 | 0.2 | 0 | 0 | 1 | 0 |
| ГХА өвчин | 21 | 0.7 | 0 | 0 | 0 | 0 |
| Хоолны хордлого | 1 | 0.0 | 0 | 0 | 0 | 0 |
| Covid-19 | 11 | 0.3 | 8013 | 246 | 44049 | 302.3 |
| Тэмбүү | 371 | 11.5 | 137 | 4.2 | 875 | 6.0 |
| Заг хүйтэн | 299 | 9.3 | 65 | 2.0 | 427 | 2.9 |
| Шинэ илэрсэн сүрьеэ | 248 | 7.7 | 130 | 4.0 | 580 | 4.0 |
| Трихомониаз | 125 | 3.9 | 43 | 1.3 | 369 | 2.5 |
| Төрөлхийн тэмбүү | 1 | 0 | 0 | 0 | 3 | 0 |

Тайлант оны эхний 05 сард дүүргийн эмнэлгийн байгууллагууд 474061 үзлэг хийсний 183101(38.6%) нь урьдчилан сэргийлэх, 84196(17.7%) нь гэрийн үзлэг байна. Дүүргийн эмнэлгийн орны тоо 388, ор хоногийн ашиглалт 30519 байна.

Тайлант хугацаанд 2690 эх шинээр жирэмсний хяналтад орсноос 16 (0.5%) нь цус багадалттай, 4 (0.9%) нь трихомониаз, 15 (3.6%) нь тэмбүүгийн өвчлөл эрэг гарсан байна. Шинээр хяналтанд орсон жирэмсэн эхчүүдийн 395 (89.1%) нь жирэмсний эхний 3 сартайдаа хяналтад орсон байна.

Зураг 10. Жирэмсний хяналтад байгаа эмэгтэйчүүд , 2021.05 сарын байдлаар




2021 оны 05-р сард артерийн гипертензи өвчний эрт илрүүлгийн үзлэгт 13467 хүн хамрагдсанаас 7674 (56,9%) эмэгтэйчүүд байна. Үүнээс давтан үзлэгт 1246(9,2%) нь хамрагдсан байна. Чихрийн шижин хэв шинж 2-ын эрт илрүүлгийн үзлэгт 9285 хүн хамрагдсанаас 5402 (58,1%) нь эмэгтэйчүүд байна.

Тайлан оны эхний 05 сарын байдлаар эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан нийт хүний 13467 (56,8%) нь артерийн гипертензи өвчний эрт илрүүлгийн үзлэгт, 9284 (39,2%) нь чихрийн шижин хэв шинж 2-ын эрт илрүүлгийн үзлэгт, 929 (3.9%) нь элэгний хорт хавдрын эрт илрүүлэгийн үзлэгт тус тус хамрагдсан байна.

Тайлант хугацаанд амбулаторт 3658 халдварт бус өвчлөл бүртгэгдсэний 2265(61,9%) нь шинээр бүртгэгдсэн байна. Тайлант хугацаанд 0-5 насны 14452 хүүхдийн өсөлтийн үндсэн үзүүлэлтийг шалгасан байна. Амбулатороор үзүүлсэн 0-5 насны хүүхдүүдийн 22 (0.1%) нь туранхай, 17(0.1%) нь тураалтай, 20(0.1%) нь өсөлтийн хоцрогдолтой хүүхэд байсан байна. Тайлант хугацаанд амбулатороор үйлчлүүлсэн 0-5 насны 10457 хүүхэд А амин дэм, 6960 хүүхэд Д амин дэм тус тус уусан байна.

Хүснэгт 10. Амбулаторийн өвчлөлийн үзүүлэлтүүд

| Үзүүлэлт | | Тоо |
|---|---|---|
| Бүртгэгдсэн халдварт бус өвчлөл-Бүгд | | 3658 |
| | Шинэ | 2265 |
| | Хуучин | 1393 |
| Хорт хавдрын өвчлөл | | 3 |
| Осол гэмтлийн өвчлөл | | 9 |
| Томуу, томуу тест өвчин (J09-J11) | | 0 |
| 0-5 хүртэлх насны хүүхдийн халдварт бус суулгалт өвчин (K52.0-K52.9) | | 0 |
| 0-5 хүртэлх насны хүүхдийн амьсгалын замын цочмог халдварт өвчин (J00-J06, J20-J22) | | 54 |
| 0-5 хүртэлх насны жинлэсэн хүүхдийн тоо | | 14452 |
| | Туранхай /жин, өндрийн үзүүлэлт/ | 22 |
| | Тураалтай /жин, насны үзүүлэлт/ | 17 |
| | Өсөлтийн хоцрогдолтой /өндөр, насны үзүүлэлт/ | 20 |
| | А амин дэм уусан | 10457 |
| | Д амин дэм уусан | 6960 |
| | Олон найрлагат бичил тэжээл хэрэглэсэн | 0 |

# ГЭМТ ХЭРЭГ

2021 оны эхний 5 сард Сонгинохайрхан дүүрэгт нийт 1020 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 245(19.4%) хэргээр буурсан байна. Тайлант хугацаанд үйлдэгдсэн нийт гэмт хэргийн 516(50.5%) нь цагдаагийн нэгдүгээр хэлтэст, 272(26.6%) нь цагдаагийн хоёрдугаар хэлтэст, 232(22.7%) нь цагдаагийн гуравдугаар хэлтэст тус тус бүртгэгджээ.

Зураг 16. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, хувиар




Тайлант хугацаанд бүртгэгдсэн нийт хэргийн 856(83.9%) нь хөнгөн гэмт хэрэг, 164(16.0%) нь хүнд гэмт хэрэг байна. Оны эхний 5 сарын байдлаар бүртгэгдсэн нийт хэргийн 371(36.3%) нь хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 21(2.0%) нь хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг, 508(49.8%) нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 23(2.2%) нь хүний бэлгийн эрх чөлөө халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 34(3.3%) нь хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг байна. Тайлант хугацаанд үйлдэгдсэн хэргийн 124(12.1%) нь согтуугаар, 22(2.1%) нь хүүхэд оролцсон, 142(13.9%) нь эмэгтэй хүн оролцсон, 39(3.8%) нь бүлэглэн үйлдсэн хэрэг байна. Тайлант хугацаанд нийт үйлдэгдсэн хэргийн 517(50.6%) нь гэр орон сууцанд, 156(15.2%) нь гудамж талбайд, 43(4.2%) нь олон нийтийн газарт, 14(1.3%) нь нийтийн тээвэрт, 5(0.4%) нь төрийн байгууллагад , 78(7.6%) нь аж ахуйн нэгжид, 36(3.5%) нь авто зам дээр тус тус гарсан байна.

Тайлант хугацаанд Сонгинохайрхан дүүрэгт бүртгэгдсэн хэргийн 149(14.6%) нь Даваа гарагт, 174(17.0%) нь Мягмар гарагт, 150(14.7%) нь Лхагва гарагт, 173(16.9%) нь Пүрэв гарагт, 142(13.9%) нь Баасан гарагт, 107(10.4%) нь Бямба гарагт, 125(12.2%) нь Ням гарагт тус тус гарчээ.

Гэмт хэргийн гаралтыг хороогоор харвал 32-р хороонд 43 гэмт хэрэг бүртгэгдсэнээс 14(32.5%) нь хулгайлах гэмт хэрэг байна. Харин хамгийн бага гэмт хэрэг гарсан 39,43-р хороонд бүртгэгдсэн гэмт хэрэг 4(0.4%) нь байна. Тайлант хугацаанд хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэсэн гэмт хэрэг 8(0.8%) бүртгэгдсэн байна. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 280 бүртгэгдсэнээс 26-р хороонд 16(5.7%) бүртгэгдсэн байна. Хулгайлах гэмт хэрэг тус дүүргийн 32-р хороо 14(1.6%), 19-р хороо 16(1.8%)-нд хамгийн их бүртгэгджээ. Залилан мэхлэх гэмт хэргийн 17(1.9%) нь 4 хороонд, 16(1.8%) 22-р хороонд бүртгэгдсэн байна. Тайлант хугацаанд гарсан нийт өмчлөх эрхийн эсрэг хэргийн 213(41.9%) нь хулгайлах гэмт хэрэг, 25(4.9%) нь дээрэмдэх, 202(39.7%) нь залилан мэхлэх, 15(2.9%) нь хөрөнгө завших, 29(5.7%) нь алдаатай гүйлгээ, гээгдсэн эд хөрөнгө завших, 14(2.7%) нь эд хөрөнгө устгах, 3(0.5%) нь мал хулгайлах гэмт хэрэг байна. 999(97.9%)Гэмт хэргийн улмаас хохирсон иргэд, хуулийн этгээд байна. Үүнээс 459(45.9%)нь эмэгтэйчүүд байна. 54(5.4%)нь төрийн албан хаагч, 10(1.0%)нь цагдаагийн албан хаагч байна. 108(10.8%)нь хувийн хэвшлийн байгууллагын ажилтан, 369(36.9%)нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 52(5.2%)нь оюутан сурагч, 385(38.5%)нь ажилгүй иргэд байна.

Хүснэгт 19.  Дүүргийн нутаг дэвсгэрт гарсан гэмт хэрэг, төрлөөр, хороогоор

| Хороо | Хүнийг алах | Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх | Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг | Хүчиндэх | Хулгайлах | Малын хулгай | Дээрэмдэх | Залилан мэхлэх | Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг | Бусад | **2021.V** | 2020.V |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | | | 9 | 2 | 3 | | | 5 | 2 | 6 | **27** | 41 |
| 2 | 2 | 1 | 12 | 1 | 5 | | 1 | 7 | 1 | 1 | **31** | 44 |
| 3 | | | 4 | | 5 | | | 6 | | 2 | **17** | 19 |
| 4 | | | 15 | 1 | 4 | | 1 | 18 | 1 | 2 | **42** | 20 |
| 5 | 1 | | 8 | | 7 | | | 3 | | 3 | **22** | 21 |
| 6 | | 1 | 10 | | 11 | | 2 | 6 | 1 | 7 | **40** | 74 |
| 7 | | | 10 | 2 | 6 | | | 2 | | 4 | **23** | 55 |
| 8 | | | 11 | 1 | 1 | | | 3 | 1 | 2 | **19** | 17 |
| 9 | 1 | | 5 | | 3 | | 1 | 4 | | 2 | **16** | 25 |
| 10 | 2 | | 6 | 1 | 1 | | 1 | 2 | 2 | 1 | **16** | 24 |
| 11 | | 1 | 6 | | 2 | | | 1 | 3 | 5 | **18** | 30 |
| 12 | | | 4 | | 7 | | | 7 | | 1 | **19** | 36 |
| 13 | | | 5 | | 7 | | | 5 | 2 | 4 | **23** | 28 |
| 14 | 1 | | 7 | | 8 | | 4 | 4 | | 4 | **25** | 18 |
| 15 | | | 8 | | 8 | | 2 | 7 | | 4 | **29** | 24 |
| 16 | | | 5 | | 3 | | 1 | 5 | 1 | 1 | **16** | 22 |
| 17 | | | 5 | | | | 1 | 4 | | 2 | **12** | 27 |
| 18 | | | 8 | | 5 | | 1 | 2 | | 4 | **20** | 55 |
| 19 | 1 | | 11 | 2 | 14 | | 2 | 9 | 1 | 4 | **44** | 55 |
| 20 | | | 15 | | 8 | | 1 | 8 | 7 | 10 | **49** | 45 |
| 21 | | | 5 | 2 | 3 | | | 1 | | 2 | **13** | 25 |
| 22 | | | 15 | | 3 | | 1 | 14 | 1 | 5 | **39** | 63 |
| 23 | | | 13 | | 2 | | | 1 | 1 | 1 | **18** | 44 |
| 24 | | | 20 | | 11 | | | 1 | 1 | 9 | **42** | 49 |
| 25 | 1 | 1 | 4 | | 4 | | 1 | 9 | | 1 | **21** | 24 |
| 26 | | | 17 | | 3 | | 2 | | | 1 | **23** | 53 |
| 27 | | | 12 | 1 | 5 | | 1 | 6 | 1 | 2 | **28** | 33 |
| 28 | | | 9 | | 3 | | | 4 | 1 | 2 | **19** | 27 |
| 29 | 2 | | 16 | 1 | 9 | | | 10 | | 12 | **50** | 54 |
| 30 | | | 3 | | 3 | | | 1 | 1 | 2 | **10** | 26 |
| 31 | | 1 | 16 | | 1 | | 1 | | | | **19** | 30 |
| 32 | | 1 | 9 | | 13 | 2 | | 9 | 3 | 12 | **49** | 63 |
| 33 | 1 | 1 | 14 | 2 | 15 | | | 6 | | 1 | **40** | 28 |
| 34 | | | 4 | | 6 | 1 | 1 | 1 | | 3 | **16** | 12 |
| 35 | | | 5 | 1 | | | | 10 | | 2 | **18** | 1 |
| 36 | | | 11 | | 1 | | | 2 | 3 | | **20** | 20 |
| 37 | | | 2 | 1 | 3 | | | 7 | | | **13** | 6 |
| 38 | | | 9 | | 2 | | 1 | 1 | 1 | 5 | **19** | 6 |
| 39 | | | 1 | | 2 | | | 1 | | | **4** | |
| 40 | | 1 | 6 | 1 | 4 | | 1 | 3 | | | **16** | 6 |
| 41 | | | 9 | | 4 | | | 4 | | | **17** | 3 |
| 42 | | | 4 | | 4 | | 1 | 2 | | 1 | **12** | 8 |
| 43 | | | 3 | | 1 | | | 1 | | 2 | **7** | 4 |
| **Нийт дүн** | **12** | **8** | **371** | **19** | **210** | **3** | **28** | **202** | **35** | **132** | **1020** | 1 265 |





**Холбоо барих**

18082 Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг
27-р хороо Агарын гудамж
Дэлхийн зөн ОУБ-ын байр
**Утас:** 70171322, 70171660
**И-мэйл:** Songinokhairkhan@nso.mn
**Вэб: www.ubstat.mn**
**www.shd.mn**